*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ МАШБАТЫН АНХБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **Зорилт.1 “Эрчим хүчний яамны холбогдох хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх”** | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Эрчим хүчний Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж, судалж, шаардлагатай тохиолдолд санал хүргүүлэх. | Өгсөн саналын тоо | 2023 онд онд Эрчим хүчний тухай хууль болон түүнтэй уялдан гарсан дүрэм, хяналтын хуудасны тухай нийт 4 санал хүргүүлж байсан. | 1-ээс багагүй | 1. Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Эрчим хүчээр хангагчийн эрх, үүрэг”-т /Ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл аваагүй болон ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын шийдвэр гараагүй барилга, байгууламжийг эрчим хүчээр хангахаас татгалзах/ гэсэн шинэ заалт нэмж оруулах,<br><br>2. “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн 1.6.5-д /Бүх төрлийн засварын давтагдах ба үргэлжилэх хугацаа, тоног төхөөрөмжийн | 2024.01.01-2024.06.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жилдээ засварт зогсох хугацааг техникийн нормативаар тогтооно. Генератор, турбин, зуухны их засварыг 4 жилд 1-ээс доошгүй удаа хийнэ./ заалтыг өөрчилж их засварын хугацааг жилээр бус ажилласан цагаар тогтоох зэрэг нийт 2 санал ЭХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлэв. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Эрчим хүчний барилга, байгууламжийг эрсдэлийн ангилалд хамааруулан шалгуур, үзүүлэлтээр үнэлэх. | Объектын тоо | 2023 онд эрсдлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр нийт 80 объект үнэлсэн. | Эрсдлийн ангилалд эрчим хүчний объектуудыг бүрэн хамруулна. | Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр аймгийн хэмжээнд 100 обьект үнэлэн шилэн хяналтын системд байрлуулж, ЭХЯ-аар баталгаажуулав. | 2024.06.01-2024.12.15 | 100% |
| 3. | Арга хэмжээ 1.3.<br>Эрчим хүчний салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 13 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, | 2023 онд 10 объектод хяналт шалгалт хийж, эрсдлийн түвшинг 100 хувь бага эрсдэлтэй болгон бууруулсан. | Хяналт шалгалтыг төлөвлөсөн хугацаанд 100 хувь хэрэгжүүлэх. | Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 11/02 дугаартай удирдамжийн хүрээнд эрсдлийн шалгуур үзүүлэлтээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 13 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 60 заалттай 9 албан шаардлага, улсын байцаагчийн 2 дүгнэлт үйлдэн тус тус хүргүүлэв.<br>Хяналт шалгалтын танилцуулга, тоон мэдээллийг ЭХЯ-ны Салбарын хяналтын газарт удирдамжид заасан | 2024.01.01-2024.06.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд цахим шуудангаар хүргүүлсэн болно. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа эрчим хүчний барилга, байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 2023 онд ЭХЯ-ны баталсан 11/06 удирдамжийн хүрээнд 2 урьдчилан сэргийлэх хяналт хийж илэрсэн зөрчлийг 100% арилгуулсан байна. | Хяналт шалгалтыг цаг тухайд нь бүрэн хийнэ. | Монгол улсын Эрчим хүчний сайдын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/52 дугаартай тушаалыг үндэслэн "Эрчим хүчний төсөл-2"-ийн хүрээнд Орхон аймгийн нутаг дэвсгэрт "Ричвелл инженеринг" ХХК-ийн гүйцэтгэж буй 6-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлын угсралтын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах 9 заалттай албан шаардлага хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулав. | 2024.05.06-2024.11.30 | 100% |
| **Зорилт.2 "Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдал хангагдсан эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь, | 2023 онд нийт 6 аж ахуйн нэгжийн өвөлжилтийн бэлтгэл байдалд хяналт хийж, илэрсэн зөрчлийн 83%-ийг | Хяналт шалгалтыг цаг тухайд нь бүрэн хийнэ. | Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 11/02 дугаартай удирдамжийн хүрээнд бие даасан халаалтын эх үүсгүүртэй 17 дугаар сургууль, 22 дугаар цэцэрлэгийн зуухны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж зөрчил арилгуулах 19 заалттай албан шаардлага 2, улсын байцаагчийн дүгнэлт 2 тус тус үйлдэн хүргүүлэв. Албан | 2024.03.25-2024.09.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгуулсан . | | шаардлагаар өгсөн үүрэг даалгавар бүрэн биелсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлал, баталгаажуулалт хийж, бүртгэлт хамруулах. | техникийн магадлал, баталгаажуу-лалтын тоо, | 2023 онд улсын бүртгэлд хамаарах нийт 18 ширхэг зуух, даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал хийж актаар баталгаажуулсан байна. | Техникийн магадлал, баталгаажуулал-тыг цаг тухайд нь 100% хийнэ. | Нийт 21 ширхэг улсын бүртгэлтэй зуух, даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал хийж актаар баримтжуулав. | 2024.01.01-2024.12.09 | 100% |
| 3. | Арга хэмжээ 2.3. Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. | Гүйцэтгэлийн хяналт шалгалтын тоо, Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь | 2023 онд 10 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, эрсдлийн түвшинг 100 хувь бага эрсдэлтэй болгон бууруулсан. | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүрэн хийж, эрсдлийн түвшинг бууруулна. | Төлөвлөгөөт хяналт шалгалтын мөрөөр 13 обьектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, мэдээллийг шилэн хяналтын цахим системд байрлуулж, ЭХЯ-аар баталгаажуулав. | 2024.09.01 2024.10.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

## Зорилт.3 "Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх"

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 3.1.<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх. | Шийдвэрлэсэн албан бичгийн тоо, Иргэний өргөдөл, гомдлын тоо, | 2023 онд иргэний 4 өргөдөл, аж ахуйн нэгж, байгууллагын 25 албан бичгийг хүлээн авч хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох эрх зүйн хүрээнд бүрэн шийдвэрлэж хариу албан ёсоор мэдэгдсэн байна. | Хууль, эрх зүйн хүрээнд хяналт шалгалтыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлнэ. | Иргэний 9 өргөдөл, аж ахуйн нэгж, байгууллагын 44 албан бичгийг хүлээн авч хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох эрх зүйн хүрээнд бүрэн шийдвэрлэж хариу албан ёсоор мэдэгдэв.<br>Мөн төлөвлөгөөт бус хяналт шалгалт 57 зохион байгуулж, хяналт шалгалтын хүрээнд дүгнэлт 27, акт 1, баталгаажуулалт 21 тус тус үйлдсэн байна. | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Удирдах дээд байгууллагууд болон удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг хангаж ажиллах, | Удирлагаас өгсөн үүрэг, чиглэлийн тоо, | 2023 онд ЭХЯ, орон нутгийн ЗДТГ-аас өгсөн нийт 3 үүрэг, чиглэлийн дагуу хяналт шалгалтын ажлыг бүрэн | Цаг тухайд нь үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангаж ажиллана. | ЗДТГ-ын газрын шуурхай хурлаас өгсөн 3 үүрэг даалгаврыг цаг тухайд нь холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлсэн. | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.3.<br>Барилга, байгууламжийг хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах. | Ажилласан улсын комиссын тоо, | 2023 онд Эрчим хүчний нийт 4 барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан. | Цаг тухайд нь холбогдох хууль, эрх зүйн хүрээнд ажиллана. | Шинээр баригдсан эрчим хүчний байгууламжийг ашиглалтад хүлээн авах нийт 8 улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллав. | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |
| 4. | Арга хэмжээ 3.4.<br>Баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх. | Хүлээлгэн өгсөн баримтын тоо, | 2023 онд төлөвлөгөөт шалгалт 10, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 2, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 16 тус тус хийж, улсын байцаагчийн үйлдсэн баримтуудыг цаг тухайд нь нэгжийн архивт хүлээлгэн өгсөн. | Хуулийн хугацаанд материалыг архивт бүрэн шилжүүлсэн байна. | Төлөвлөгөөт шалгалт 13, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 57 тус тус хийж, улсын байцаагчийн үйлдсэн баримтуудыг цаг тухайд нь нэгжийн архивт хүлээлгэн өгсөн. | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |
| 5. | Арга хэмжээ 3.5.<br>ЗДТГ-ын эцэг эхийн зөвлөлд орж ажиллах. | Зохион байгуулж, оролцсон үйл ажиллагааны тоо, | 2023 оны хүүхдийн баяр, шинэ жилээр | Цаг тухайд нь үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно. | Зөвлөлийн гишүүний хувьд хүүхдийн баяр, шинэ жилийн баярын арга хэмжээтэй холбоотой зохион | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |

93

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ЗДТГ-ын нийт албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг өгөх арга хэмжээг зохион байгуулахад оролцов. | | байгуулалтын арга хэмжээнд оролцон ажиллаж байна. | | |
| **ХОЁР. МЭДЛЭГ УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>Төрийн албан зөвлөл, удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан албан тушаалын чиг үүрэгт хамаарал бүхий сургалтад бүрэн хамрагдах. | Хамрагдсан сургалтын тоо | "Алсын хараа-2050" сэдэвт цахим сургалтад хамрагдан, шалгалт өгч үнэмлэх авсан. | Сургалтуудад цаг тухайд нь хамрагдана. | - Монгол улсын ЗГ, ЦХХХЯ-наас зохион байгуулж буй шилэн хяналтын системд ажиллах сургалтад хамрагдан, хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- ЗДТГ-аас зохион байгуулж буй үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрагдан суралцаж байна.<br>- 7*4*10 сургалтуудад ажлын боломжоороо хамрагдаж байна. | 2024.01.01<br>2024.12.09 | 100% |

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР/ АРГА ХЭМЖЭЭ/-НИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийг үндэслэн Эрчим хүчний яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 11/01 дугаартай удирдамжийн дагуу Орхон аймгийн нутаг | Шалгалтад хамрагдсан объектийн тоо | - | Хуулийн хэрэгжилт хангагдана. | "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7 дахь заалтыг үндэслэн "Ачит ихт" ХХК-ийн харьяа зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг | 2024.05.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэвсгэрт байрлах "Ачит ихт" ХХК-ийн харьяа зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг нь зогсоох, | | | | 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоож, эрчим хүчний хэрэглээг нь улсын байцаагчийн актаар түдгэлзүүлсэн. Улсын ахлах байцаагчийн 2024 оны 08 сарын 22-ны өдрийн 11-25-02/025/01 дугаартай шийдвэрээр актын үргэлжлэх хугацааг зогсоосон болно. | | |
| 2. | Монгол улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/197 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг үндэслэн "Ачит ихт" ХХК-ийн харьяа зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээх. | Шалгалтад хамрагдсан объектийн тоо | - | Хуулийн хэрэгжилт хангагдана. | 2024 оны 08 сарын 22-ны өдрийн 11-25-02/025/01 дугаартай Улсын ахлах байцаагчийн шийдвэрээр актын үйлчлэх хугацааг зогсоож, цахилгаан эрчим хүчний хэрэглээг сэргээн хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангав. | 2024.08.22 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ М.АНХБАЯР 2024.12.09